

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ 15 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 15 дугаар хуралдааныг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 14 цаг 41 минутад Засаг даргын Тамгын газрын II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 75.0 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Хуучирч муудсан шугам сүлжээний асуудал хэлэлцүүлэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хуучирч муудсан шугам сүлжээний асуудлыг хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусгаж, өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хүрээнд Ховд хотын нийтийн орон сууцны цэвэр, бохир, дулааны шугам сүлжээний засвар, шинэчлэлтийн ажилд хөрөнгө гаргах тогтоолын төсөл боловсруулж таницуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүх нарт үүрэг болгов.</p>
2	Бадамлах дөл” ХХК-тай байгуулсан гэрээ цуцлах асуудлыг хэлэлцүүлэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь: Махны нөөцийг 200,0 сая төгрөгөөр, махыг жижиглэх, тээвэрлэх үйл ажиллагааны зардалд 38.0 сая төгрөг зарцуулах шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд үүрэг болгов.</p>
3	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй гүйцэтгэл танилцуулах тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Улсын драмын эрдмийн театрын уран бүтээлчдийн тоглолт зохион байгуулсан зардалд 1,075,500 төгрөг, Өмнөд америкийн Эквадор улсын Qirwa Anka хамтлаг “Ховдын хүчтэнгүүд” арга хэмжээд тоглуулсан зардалд 9,435,100 төгрөг, Урианхай, Тува, Дөрвөд угсаатны өв соёл, ёс уламжлал, зан заншил, язгуур урлагийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, зохион байгуулах зардалд 2,648,000 төгрөг, Захчин түмний өв соёлын Тонжоо наадмын зохион байгуулалтын зардалд 1,500,000 төгрөг, Хан Жаргалантын хурд 2022 Баруун бүсийн даншиг наадам зохион байгуулсан зардалд 7,637,900 төгрөг; 2. Шадар сайд С.Амарсайханаар ахлуулсан ажлын хэсэг манай аймагт ажилласан зардалд 2,603,300 төгрөг, Онцгой байдлын тэргүүн дэд бөгөөд штабын дарга, бригадын генерал Ж.Чүлтэмсүрэнгээр ахлуулсан ажлын хэсгийн манай аймаг ажилласан 2,915,800 төгрөг, ахмад уран бүтээлчдэд хүндэтгэл үзүүлсэн зардалд 278,500 төгрөг, Ховд аймгаас төрсөн нэр бүхий</p>

		<p>9 гавьяат цолтонд хүндэтгэл үзүүлэх зардалд 4,920,500 төгрөг, Ерөнхий сайдын зөвлөх манай аймагт ажилласан зардалд 1,467,150 төгрөг;</p> <p>3. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны зардалд 2,669,200 төгрөг;</p> <p>4. Мөст, Зэрэг, Дуут сумдын ойн баярт дурсамж хийлгэсэн зардалд 180,000 төгрөг (нэг зуун наян мянга), Төрийн дээд шагнал гардуулах үйл ажиллагааны зардалд 403,075 төгрөг (дөрвөн зуун гурван мянга далан тав), Дэлхийн банкны Монгол улсыг хариуцсан менежер бөгөөд суурин төлөөлөгч Андрей Михнев тэргүүтэй төлөөлөгчидтэй цаашид манай аймагт хамтран хэрэгжүүлж болох төсөл хөтөлбөрийн талаар хийсэн уулзалт арга хэмжээний зардалд 2,074,950 (хоёр сая далан дөрвөн мянга есөн зуун тавь), TEDxKhovd арга хэмжээний зардалд 583,950 төгрөгийг тус тус аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах захирамжийн төсөл боловсруулан танилцуулахыг Санхүү, аж ахуйн тасгийн нягтлан бодогч Б.Энхмандалд үүрэг болгов.</p>
4	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын дагуу худалдан борлуулах болон татан төвлөрүүлсэн автомашины жагсаалт танилцуулах тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн хэмнэлтийн хууль болон Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн шатахууны зардлыг гүйцэтгэлээр нь олгохоор болов.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР